



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2026 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Дельта софт ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дельта софт ХХК-ийн хүсэлтийг үндэслэн тус хуулийн этгээдийн Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” 12100821 тоот тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ /-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР